

**АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦНЫ 200... ОНЫ
... Р ХАГАС, БҮТЭН ЖИЛИЙН МЭДЭЭ**

Аймаг, хот
Сум, дүүрэг
Баг, хороо
Өмчийн хэлбэр
Хаяг /орон сууцны нэр, дугаар/

дугаар	

1. Баг, хорооны Засаг дарга нь өөрийн нутаг дэвсгэрт шинээр ашиглалтад орсон орон сууцны мэдээг барилга нэг бүрээр гаргаж жил бүрийн 7, 1-р сарын 10-ны дотор сумын ЗДТГ, дүүргийн статистикийн хэлтэст маягтаар
2. Жил бүрийн 7, 1-р сарын 15-ны дотор сум нь аймгийн статистикийн хэлтэст маягтаар, дүүрэг нь нийслэлийн статистикийн газарт электрон шуудангаар
3. Аймаг, нийслэлийн Статистикийн хэлтэс, газар нь жил бүрийн 7, 1-р сарын 21-нд ҮСГ-т электрон шуудангаар тус тус ирүүлнэ.

1. САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛБЭР, ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ

/мян.төг/

Санхүүжилтийн хэлбэр	мд	Хөрөнгийн хэмжээ
A	B	1
Төсвийн хөрөнгө оруулалт	1	
Гадаадын зээл, тусламж	2	
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	3	
Банкны зээл	4	
Үнэт цаас гаргасны /борлуулсны/	5	
Өөрийн хөрөнгө оруулалт	6	
Бусад	7	

2. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦНЫ ТОО, зориулалтаар

Үзүүлэлт	мд	Нийтийн зориулалттай орон сууц	Сууцны тусдаа байшин
A	B	1	2
Сууцны тоо, бүгд:	8		
Өрөөгөөр	1 өрөө	9	
	2 өрөө	10	
	3 өрөө	11	
	4 ба түүнээс дээш өрөө	12	
Нийт талбай, кв.м	13		
үүнээс: сууцны талбай, кв.м	14		
Давхрын тоо	15		
Орцны тоо	16		
Цахилгаан шатны тоо	17		
Төвлөрсөн шугам, сүлжээнд холбогдсон сууцны тоо	18		
Үүнээс	Цэвэр усны /халуун, хүйтэн ус/	19	
	үүнээс: зөвхөн хүйтэн ус	20	
	Ариутгах татуургын	21	
	Халаалтын	22	
Цахилгааны	23		
Тухайн сууцанд амьдарч байгаа өрхийн тоо	24		
Тухайн сууцанд амьдарч байгаа хүний тоо	25		
Автомашинны гарааштай эсэх	26		
Гараашийн багтаамж /машины тоо/	27		
Гараашийн талбай /кв.м/	28		
Орон сууцны байшингийн доторх үйлчилгээний байгууламж	29		
Гуанз, цайны газар /талбай, кв.м/	30		
Дэлгүүр, эмийн сан /талбай, кв.м/	31		
Үсчин, гоо сайхан /суудлын тоо/	32		
Саун, бассейн /талбай, кв.м/	33		х
Билльярд, спорт /талбай, кв.м/	34		

Мэдээг гаргасан:

Баг, хорооны Засаг дарга..... /

/

Маягт нөхөх заавар

Тухайн баг, хорооны нутаг дэвсгэр дээр шинээр барьж, ашиглалтад оруулсан нийтийн зориулалттай болон сууцны тусдаа байшинг барилга тус бүрээр гаргана. Тодруулбал, тухайн баг, хорооны нутаг дэвсгэрт 3 байшин баригдсан тохиолдолд тус бүрд нэг нэг маягтаар гаргана.

Хаягийн хэсэгт аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нэр, кодыг, орон сууцны нэр дугаарыг тус тус бичнэ.

Өмчийн хэлбэрт: төрийн өмчийг -1, хувийн өмчийг 2 гэсэн кодоор дугаарлана.

Санхүүжилт хийгдсэн хөрөнгийн хэмжээг санхүүжилтийн нэр төрөл бүрээр нь гаргана. Тухайн орон сууц хэдэн ч төрлийн санхүүжилт авсан байна, тэр болгоны мөнгөн дүнг харгалзах нүдэнд бичнэ. **Төсвийн хөрөнгө оруулалтад** улсын төсөв, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт хамаарна. **Гадаадын зээл, тусламжид** гадаадын хөнгөлөлттэй болон хөнгөлөлтгүй зээл, бүцэлтгүй тусламжийг хамааруулна.

орно. **Гадаадын шууд хөрөнгө оруулалт** гэж Монгол улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж байгуулах, эсхүл Монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчаас буцааж төлөхгүй нөхцлөөр Монгол улсад оруулж буй мөнгөн болон хөрөнгийн хэмжээг хэлнэ.

Банкны зээлд арилжааны банк болон банк бус санхүүгийн байгууллагаас хөрөнгө оруулалтад зориулж олгосон зээл хамаарна. **Өөрийн хөрөнгө оруулалтад** аж ахуй нэгж, байгууллага болон хувь хүний хөрөнгийг хамааруулна. **Бусад** гэсэн үзүүлэлтэд дээрх нэр төрлөөс гадна санхүүжилтийн эх үүсвэрийг хамааруулна.

Орон сууц гэж хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн орон сууцны байшин, сууцны тусдаа байшинг хэлнэ.

Нийтийн зориулалттай орон сууц гэж дөрөв ба түүнээс дээш айлын сууцны зориулалттай барилгыг хэлнэ.

/1999 оны 4-р сарын 22-ны өдөр батлагдсан "Орон сууцны тухай" Монгол Улсын хуулиас/

Сууцны тусдаа байшин гэж 4 хүртэлх айл, өрх амьдрах зориулалттай, батлагдсан зураг төслөөр болон төсөлгүйгээр баригдсан, инженерийн шугам сүлжээнд холбогдсон болон холбогдоогүй байшинг хэлнэ.

Сууцны тоог тодорхойлохдоо олон айл суух, нийтийн зориулалттай орон сууцыг нэг сууц гэж үзэхгүй, айл бүрийн хаалганы тоогоор хэдэн сууц болохыг тодорхойлж 8-р мөрөнд бичнэ.

Нийт талбайд унтлагын болон амралт, зочны, ажлын өрөө, галын өрөө, ариун цэврийн өрөө, сууц доторхи коридор, агуулахын талбайг оруулна. Нийт талбайн хэмжээг 13-р мөрөнд бичнэ.

Сууцны талбайд зөвхөн унтлагын болон амралт, зочны, ажлын өрөөний талбай хамааруулна. Сууцны талбайн хэмжээг 14-р мөрөнд бичнэ.

Давхрын тоог маягтны 15-р мөрөнд, **орцны тоог** 16-р мөрөнд, **цахилгаан шатны тоог** 17-р мөрөнд тус тус бичнэ.

Төвлөрсөн шугам сүлжээ гэж хот, суурин газрын хүн амыг цэвэр ус, дулаан, цахилгаанаар хангах, бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам, сүлжээ, барилга байгууламжийг хэлнэ.

Ариутгах татуурга /Ариун цэврийн байгууламж/ гэж хэрэглээнээс гарсан бохир ус цуглуулах, татан зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламжийг хэлнэ. /2002 оны 6-р сарын 13- ны өдөр батлагдсан "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" Монгол Улсын хуулиас/

Шугам сүлжээ гэсэн ойлголтод цэвэр ус дамжуулах, хуваарилах, хэрэглэгчдэд хүргэх, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах байгууламжийг хамааруулна. /2002 оны 6-р сарын 13-ны өдөр батлагдсан "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" Монгол Улсын хуулиас/

Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон сууцанд амьдарч байгаа өрхийн тоог 24-р мөрөнд, үүнээс өрхийн хүн амын тоог 25-р мөрөнд бичнэ. 26-р мөрөнд автомашины гарааштай бол /+/ тэмдэг, үгүй бол /-/ тэмдгээр нөхөж бичнэ. 27-р мөрөнд гараашийн багтаамжийг машины тоогоор илэрхийлж бичнэ. Тодруулбал, 2 машин ордог гарааш байхад гараашийн багтаамжийг 2 гэж үзнэ. Гараашийн талбайг кв.м –ээр хэмжиж 28-р мөрөнд бичнэ.

Орон сууцны байшингийн доторх үйлчилгээний байгууламжтай эсэхийг тодорхойлох үзүүлэлтүүд болох гаунз, цайны газар, дэлгүүр эмийн сан, үсчин, гоо сайхан, саун бассейн, билльярд, спорт гэсэн үзүүлэлтүүдийг тэмдгээр харгалзах мөрөнд нөхөж бичнэ.

х- Тэмдэглэгдсэн нүдийг бөглөхгүй.

Балансын шалгалт:

Мөр 8=9+10+11+12 байна.